



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.12.20 № ХЭГ/2634
танай _____-ны № _____-т

Ерөнхий сайдын мэдээлэл
хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх "Авлигатай тэмцэх 5Ш ажиллагаа"-ны хүрээнд хэрэгжүүлсэн "Шил" ажиллагаа"-ны талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245011255

“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 5Ш АЖИЛЛАГАА”-НЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “ШИЛ АЖИЛЛАГАА”-НЫ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д дэвшүүлсэн төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, бүтээмжийг дээшлүүлэх, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах зорилтын хүрээнд “Шил ажиллагаа”-г хэрэгжүүлж байна.

“Шил ажиллагаа”-гавлига, хүнд суртлыг бууруулах, иргэд нээлттэй мэдээлэлтэй нэг цонхоор, саадгүй байдлаар танилцах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, мэдээлэл хариуцагч байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд үнэлгээ хийж, “Шилэн индекс”-ийг зарлах зорилготойноор хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын хөгжлийг сааруулагч гол хүчин зүйлсийн нэг болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлд нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлигыг үл тэвчих олон нийтийн хандлагыг төлөвшүүлэх, иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан авлигыг бүх шатанд таслан зогсоох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврыг гаргасан.

“Шил ажиллагаа”-ны хүрээнд “shilen.gov.mn” цахим системийг 2023 оны гуравдугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулж, иргэд, олон нийтийг нээлттэй мэдээллээр хангаж, үндэсний хэмжээнд “Шилэн индекс”-ийг зарласан ба энэ хүрээнд 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж ажиллалаа.

Мөн яам, Засгийн газрын агентлаг болон аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит, өмчийн оролцоотой мэдээлэл хариуцагч байгууллагын 604 гаруй багц мэдээллийг “shilen.gov.mn” системд нээлттэй байршуулаад байна.

Одоогийн байдлаар тус системд иргэдээс нийт 15,624,726 удаа хандаж, холбогдох мэдээллийг авсан байна.

Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем буюу “shilen.gov.mn” системд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар нийт 39 төрлийн 970,355 мэдээлэл байршуулсан. Үүнд:

1.Богдхан уулын дархан цаазат газар, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамаарах 78 байршилд 4,568 га газрыг 2,079 хүн, хуулийн этгээдэд ашиглуулах шийдвэр гаргасан талаар;

2.Хүн, хуулийн этгээдийн эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн ерөнхий үнэлгээний 10,812, нарийвчилсан үнэлгээний 4,696 буюу нийт 15,508 үнэлгээний талаар (2008 оноос хойш);

3.Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 13,399 барилгад өгсөн архитектур төлөвлөлтийн даалгавар, 4,721 барилгад өгсөн дүгнэлт болон тус комиссын бүрэлдэхүүний талаарх мэдээлэл (2008 оноос хойш);

4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой 238 хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 1,608 гишүүний талаарх мэдээлэл;

5.Төрийн өмчид хамаарах 93.5 м.кв талбай бүхий объектыг түрээслэгч 102, түрээслүүлэгч 570 байгууллагын талаарх мэдээлэл;

6.Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой доор дурдсан багц мэдээлэл:

-Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2009-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Хөдөө аж ахуйн корпорацаас 1994-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Улсын авто замын сангийн 2008-2023 оны хооронд нийт 107 хуулийн этгээдэд олгосон 187.4 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Соёл, урлагийг дэмжих сангийн 2020–2022 оны хооронд нийт 241 хүн, хуулийн этгээдэд олгосон 6.5 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Кино урлагийг дэмжих сангийн 2023 онд 11 хүн, хуулийн этгээдтэй байгуулсан 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт, одоо хэрэгжүүлж байгаа гэрээний мэдээллийг жагсаалтын хамт;

-Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн 2012–2023 оны хооронд гэмт хэргийн хохирогч болсон 484 иргэнд олгосон 2.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 1.6 тэрбум төгрөгийн авлагын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Боловсролын зээлийн сангийн 1996-2023 оны хооронд нийт 2836 суралцагчид гадаадын зээл, тэтгэлгийн чиглэлээр олгосон 32.8 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнээс 316.0 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

-Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017-2023 оны хооронд давхардсан тоогоор 666 байгууллага, 18,477 суралцагчид олгосон 72.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын мэдээллийг жагсаалтын хамт;

-Шинжлэх ухаан, технологийн сангийн 2007–2022 оны хооронд нийт 381 хүн, хуулийн этгээдэд олгосон 2780 төсөл, хөтөлбөрийн 151.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2013-2022 оны хооронд 724 хүн, хуулийн этгээдэд олгосон 1091 төсөл, хөтөлбөрийн 17.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас 2009-2023 оны хооронд 2000 гаруй иргэнд 3.1 тэрбум төгрөгийн тусламж олгосон талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Нийгмийн халамжийн сангийн 2008-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Нийгмийн даатгалын сангийн 2008-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Хүүхдийн төлөө сангийн 2021-2023 оны хооронд үүсгэсэн нийт 11.0 тэрбум төгрөгийн хуримтлал болон үүнээс 106.7 сая төгрөгийг нийт 45 хүүхдэд 2 төрлөөр зарцуулсан талаарх мэдээлэл;

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Ирээдүйн өв сангийн 2017-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Төсвийн тогтворжуулалтын сангийн 2011-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Эрүүл мэндийг дэмжих сангийн 2008-2023 оны хооронд нийт 739 хуулийн этгээдэд олгосон 30.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг жагсаалтын хамт;

-Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2009-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Спортыг дэмжих сангийн 2017-2019 оны хооронд нийт 57 хуулийн этгээдэд олгосон 66 төсөл, арга хэмжээний 4.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаар.

7.Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийн талаарх мэдээлэл (2008 оноос хойш);

8.Эрх бүхий 18 байгууллагаас олгодог 14,344 зөвшөөрөл, ашигт малтмалын хайгуулын 885, ашиглалтын 1713 тусгай зөвшөөрлийн мэдээллийг жагсаалт.

Түүнчлэн, “Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем”-ийн 2.0 хувилбарыг хөгжүүлж, хиймэл оюуны ухааны сүүлийн үеийн GPT технологийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд нэвтрүүлээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж, үнэлгээний мөрөөр сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Нийт 172 байгууллагыг үнэлэхэд дундаж үзүүлэлт 77.2 хувьтай байна. Үүнээс:

- Төрийн захиргааны төв байгууллагын дундаж үзүүлэлт 90 хувь;
- Төрийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 93.7 хувь;
- Нутгийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 72.6 хувь.

Мэдээлэл хариуцагч 974 байгууллагын 1136 албан тушаалтан “Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем”-д тоон гарын үсгээр нэвтэрч байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг өөрчлөлтийн хамт тухай бүр байршуулах боломжийг бүрдүүллээ.

“Шил ажиллагаа”-ны үр дүнд төрийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт дээшилж, Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цахим засаглалын хөгжлийн индексээр 2024 онд 28 байраар урагшилж, 193 орноос 46 дугаарт жагссан байна.

Түүнчлэн төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн шийдвэр, тайлан мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах нь компанийн сайн засаглалын олон улсын суурь зарчим юм.

Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын хаалттай байдал нь хуулийн этгээд үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн өмч үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байгаа тул төрийн өмчит 119 компанийн ашиг, алдагдлын болон төсөвт төвлөрүүлсэн татварын мэдээллийг “Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем” болон “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас”-нд ил тод байршууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа ил тод, хараат бус, хөндлөнгийн хяналттай байх зарчимд үндэслэн гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах, шаардлагатай бол Засгийн газрын шийдвэрээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар аудит хийлгэх зохицуулалтыг тусгасан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулан олон нийтээс санал авч байна.

---oOo---

"ШИЛЭН ИНДЕКС"-ИЙН ҮНЭЛГЭЭ
(жагсаалтаар)

№	Байгууллага	Шилэн индексийн үнэлгээ /%/
1.	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар	100
2.	Шүүх шинжилгээний ерөнхий газар	99
3.	Архивын ерөнхий газар	98
4.	Гадаадын иргэн, харьяатын газар	98
5.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	98
6.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	98
7.	Хууль зүйн үндэсний хүрээлэн	98
8.	Хил хамгаалах ерөнхий газар	97
9.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	97
10.	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	97
11.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	97
12.	Дотоод хэргийн их сургууль	97
13.	Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар	97
14.	Хууль зүйн туслалцааны төв	97
15.	Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	97
16.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	97
17.	Харилцаа холбооны зохицуулах хороо	96
18.	Улсын бүртгэлийн ерөнхий газар	96
19.	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	96
20.	Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар	96
21.	Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	96
22.	Оюуны өмчийн газар	95
23.	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар	95
24.	Орхон аймгийн Улсын бүртгэлийн газар	95
25.	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар	95
26.	Сангийн яам	94
27.	Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар	94
28.	Эрчим хүчний яам	94
29.	Эдийн засаг, хөгжлийн яам	94
30.	Орхон аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	94
31.	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газар	94
32.	Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	94
33.	Эрүүл мэндийн хөгжлийн төв	93
34.	Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар	93
35.	Ховд аймгийн Нийгмийн даатгалын газар	93
36.	Дундговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	93
37.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	92
38.	Монополын эсрэг газар	92
39.	Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газар	92
40.	Дундговь аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	92
41.	Төв аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	92
42.	Иргэний нисэхийн ерөнхий газар	91
43.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	91
44.	Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	91
45.	Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	91
46.	Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	91
47.	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар	90

48.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	90
49.	"И-Монгол академи" УТҮГ	90
50.	Цагдаагийн ерөнхий газар	90
51.	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар	90
52.	Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	90
53.	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	90
54.	Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газар	90
55.	Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	90
56.	Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	90
57.	Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар	89
58.	Төрийн худалдан авах ажиллагааны газар	89
59.	Булган аймгийн Засаг даргын Тамгын газар	89
60.	Сүхбаатар аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	89
61.	Дорнод аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	89
62.	Дундговь аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	89
63.	Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	89
64.	Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	89
65.	Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	89
66.	Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	89
67.	Гаалийн ерөнхий газар	88
68.	Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	88
69.	Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар	88
70.	Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газар	88
71.	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар	88
72.	Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	88
73.	Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	87
74.	Баян-Өлгий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	87
75.	Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газар	87
76.	Дундговь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар	87
77.	Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	87
78.	Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	86
79.	Говьсүмбэр аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	86
80.	Дорноговь аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	86
81.	Увс аймгийн Нийгмийн даатгалын газар	86
82.	Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	86
83.	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газар	86
84.	Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	86
85.	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	85
86.	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар	85
87.	Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	85
88.	Батлан хамгаалах яам	84
89.	Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	84
90.	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	83
91.	Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар	83
92.	Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газар	83
93.	Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	83
94.	Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	83
95.	Кино урлагийн зөвлөлийн Ажлын алба	82
96.	Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар	82
97.	Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	82
98.	Өмнөговь аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	82

99.	Хууль зүй, дотоод хэргийн яам	81
100.	Зам, тээврийн яам	81
101.	Архангай аймгийн Эрүүл мэндийн газар	81
102.	Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын Тамгын газар	81
103.	Дундговь аймгийн Худалдан авах ажиллагааны газар	80
104.	Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	80
105.	Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар	79
106.	Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	79
107.	Увс аймгийн Засаг даргын Тамгын газар	78
108.	Завхан аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	78
109.	Хархорум музей	78
110.	Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	78
111.	Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газар	77
112.	Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын газар	77
113.	Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	77
114.	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	76
115.	Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	76
116.	Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газар	75
117.	Булган аймгийн Нийгмийн даатгалын газар	75
118.	Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар	75
119.	Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар	74
120.	Стандарт, хэмжил зүйн газар	74
121.	Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар	73
122.	Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	72
123.	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар	72
124.	Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар	72
125.	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар	72
126.	Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	72
127.	Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгийн газар	71
128.	Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар	71
129.	Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	71
130.	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	70
131.	Дорноговь аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газар	69
132.	Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар	68
133.	Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	67
134.	Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газар	66
135.	Байгалийн түүхийн музей	65
136.	Дундговь аймгийн Татварын газар	65
137.	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	63
138.	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газар	63
139.	Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	63
140.	Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар	62
141.	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газар	62
142.	Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газар	62
143.	Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	61

144.	Төв аймгийн Нийгмийн даатгалын газар	61
145.	Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар	59
146.	Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	56
147.	Өвөрхангай аймгийн Тарагт сумын Засаг даргын Тамгын газар	54
148.	Дундговь аймгийн Соёл урлагийн газар	54
149.	Баянхонгор аймгийн Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар	52
150.	Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг даргын Тамгын газар	52
151.	Соёлын өвийн үндэсний төв	50
152.	Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар	50
153.	Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар	50
154.	Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар	50
155.	Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	49
156.	Монголын театрын музей	48
157.	Дүрслэх урлагийн музей	47
158.	Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын газар	44
159.	Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	44
160.	Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар	39
161.	Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа	36
162.	Дундговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	36
163.	Чойжин ламын сүм музей	34
164.	Улсын драмын эрдмийн театр	30
165.	Хөшөөцайдам музей	25
166.	Баянхонгор аймгийн цэвэр хот	25
167.	Улсын филармони	23
168.	Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	19
169.	Хүүхэд залуучуудын театр	15
170.	Монголын уран зургийн галерей	13
171.	Хүүхдийн төв номын сан	13
172.	Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа	6

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙДЫН
ХИЙХ "ШИЛ" АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛД
ОРОЛЦОХ АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

№	Овог нэр /бүтнээр/	Албан тушаал	Утасны дугаар	РД
1.	Пушаа Алтан-Од	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга	99093386	ЖИ85062039
2.	Батчулуун Бат-Өлзий	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	88889899	ЖВ86013011
3.	Ганбат Энхтулга	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч	86120000	НЧ87100506
4.	Мөнхдорж Баттулга	"Үндэсний дата төв" УТҮГ-ын Захирал	88110704	УС85022135
5.	Бавуужав Мягмарнаран	"И-Монгол Академи" УТҮГ-ын Захирал	88888868	ВЮ83080119

---- оОо ----